



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7700 7734, Факс: (976-11) 32 01 54,
E-mail: ub@audit.gov.mn; http://www.city.audit.mn

2018.03.23 № 911
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗРЫН ДАРГА, ТӨСВИЙН ШУУД
ЗАХИРАГЧ Л.ТӨМӨРБААТАР
ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйл, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2017 оны жилийн эцсийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем

болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Төсвийг үр ашиггүй төлөвлөж зарцуулсан, цалин хөлс, нэмэгдэл, үр дүнгийн урамшуулал тогтоосон хувиас илүү тооцон олгосон, бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа хууль журмыг мөрдөөгүй, санхүүгийн анхан шатны баримтын иж бүрдэл дутуу, төвлөрүүлээгүй бэлэн мөнгөний үлдэгдэлтэй, авлага өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, зарим дансны бичилт буруу хийгдсэн, өмнөх аудитаар өгсөн зөвлөмж биелэгдээгүй зэрэг нийт 1 815 187.1 мянган төгрөгийн зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн хэмжилт, үнэн зөв байдал, иж бүрэн байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



С.ЭНХБААТАР

НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

Аудитын тайлан

Б.Баттуяа

Дэд дарга, тэргүүлэх аудитор
өрөөний утас: 327734

Хавсралт 1: Агуулга

Ц.Бат-Өлзий

Санхүүгийн аудитын II хэлтсийн
дарга бөгөөд аудитын
менежер

Хавсралт 2: Аудитын тайлан

өрөөний утас: 315558

Хавсралт 3: Байгууллагаас ирүүлсэн хариу

Аудитор

Б.Тэгшлхам

Хавсралт 4: Менежментийн захидал

Хавсралт 5: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

Хавсралт 6: Аудит хийгдсэн төсвийн
гүйцэтгэлийн тайлан

ТАБ-ын хаяг: Нийслэл дэх
Төрийн аудитын газар

Байршил: Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 1,
Амарын гудамж 2, Соёлын төв
өргөө, "Г" корпус, 4-5 дугаар
давхар

Вэб: www.city.audit.mn

2018 оны 03 дугаар сарын 25

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ТАБ	Төрийн аудитын байгууллага
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НТТТ	Нийслэлийн түргэн тусламжийн төв
НЭМГ	Нийслэлийн Эрүүл мэндийн газар
НЗӨСТ	Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төв
НШЭНТ	Нийслэлийн шүд эрүү нүүрний төв
УАУЭСКТ	Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клинкийн төв
БГД-ийн ЭМТ	БГД-ийн Эрүүл мэндийн төв
БЗД-ийн ЭМТ	Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв
СБД-ийн ЭМТ	Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төв
СБД-ийн НЭ	Сүхбаатар дүүргийн Нэгдсэн эмнэлэг
СХД-ийн ЭМТ	Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв
СХД-ийн НЭ	Сонгинохайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлэг
ЧД-ийн ЭМТ	Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төв
ХУД-ийн ЭМТ	Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв
ХУД-ийн НЭ	Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлэг
БНД-ийн ЭМТ	Багануур дүүргийн Эрүүл мэндийн төв
НХД-ийн ЭМТ	Налайх дүүргийн Эрүүл мэндийн төв
БХД-ийн ЭМТ	Багахангай дүүргийн Эрүүл мэндийн төв

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйл, 18 дугаар зүйлийн 18.2-д Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд НТАГ-2018/1/СТА-ТТЗ баталгаажуулах аудит хийлээ.

Аудитыг Төсвийн, Төрийн аудитын, Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2017 оны санхүүгийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн яамнаас гаргасан заавар, журам, тухайн төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь НТАГ-ын үүрэг юм.

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитыг 2018 оны 3 дугаар сарын 05-наас 2018 оны 3 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн НТАГ-ын санхүүгийн аудитын II хэлтсийн аудитор Б.Тэгшлхам 2018 оны 3 дугаар сарын 05-наас 3 дугаар сарын 25-ны хооронд хийж гүйцэтгэв.

Тус байгууллага нь 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд 2018 оны 3 дугаар сарын 06-ны өдөр 01/212 тоот албан бичгээр НТАГ-т ирүүлсэн.

Аудитын тайлан, гэрчилгээг 2018 оны 3 дугаар сарын 25-нд Нийслэлийн Эрүүл мэндийн газрын удирдлагад хүргүүлж байна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын төсвийн захирагч нь Төсвийн, Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн, Эрүүл мэндийн хуулиуд болон холбогдох тогтоол, шийдвэр, журам, зааврын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуулинд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Тус байгууллагын дүрмэнд “Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагийн хувьд эрүүл мэндийн асуудлаар Монгол Улсын Их хурал, Засгийн газар, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг дарга болон бусад байгууллагуудаас гаргасан бодлого шийдвэрийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх, зохицуулах, хэрэгжилтийг хянах, хангах чиг үүрэгтэй ажиллана.” гэж байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 16.1 “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасны дагуу Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга болон түүний харъяа дүүргүүдийн Эрүүл мэндийн нэгдэл, амаржих газрууд, бусад эрүүл мэндийн байгууллагуудын дарга нар нь төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааг Эрүүл мэндийн сайдын багцаас санхүүжүүлж, нийслэл, дүүргийн төрийн сангаас олгосон байна.

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Эрүүл мэндийн яамны салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2010 онд боловсруулан Эрүүл мэндийн сайдын 2010 оны 138 тоот тушаалаар мөрдөж эхэлсэн бөгөөд тайлант онд өөрчлөлт ороогүй байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн боловч стандартын өөрчлөлт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох шинэчлэгдсэн заавар, журамд нийцүүлэн өөрчлөх шаардлагатай байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд 9 дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг 3, амаржих газар 3, Нийслэлийн Эрүүл мэндийн газар /НЭМГ/, Нийслэлийн түргэн тусламжийн төв /НТТТ/, “Энэрэл” эмнэлэг, Наркологийн эмнэлэг, Нийслэлийн шүд, эрүү, нүүрний төв /НШЭНТ/, Нийслэлийн ЗООНОЗ өвчин судлалын төв /НЗӨСТ/, нийт 21 эрүүл мэндийн байгууллага нэгтгэсэн.

Тухайн байгууллагуудын төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажилласан.

Энэ газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар тус газрын 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс байгууллагын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд уламжлалт

болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 6-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах ажиллагааг Сангийн яамны “Этайлан” програмаар боловсруулан санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргасан байна.

Дотоод хяналт

Санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой.

Тус хэлтсийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага зэрэг гэж тооцсон ба дахин хянахад санхүүгийн зарим үйл ажиллагаанд дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

Нийслэлийн Эрүүл мэндийн газар болон харьяа эрүүл мэндийн байгууллагуудад 2017 онд улсын төсвөөс 38 759 127.2 мянга, эрүүл мэндийн даатгалын сангаас 41 247 897.9 мянга, төсөвт байгууллагуудын өөрийн орлогоор 2 225 082.3 мянга, үндсэн бус үйл ажиллагааны орлогоор 73 385.3 мянга, нийт 82 305 492.7 мянган төгрөгийн санхүүжилт, орлого орсон.

Гүйцэтгэлээр урсгал үйл ажиллагааны зардалд 81 201 291.3 мянган төгрөг зарцуулж, төсвийн үлдэгдэл 1 104 201.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 47.6 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй, тайлант онд 3 226 465.7 мянган төгрөгийн орлого орж, 3 147 096.2 мянган төгрөгийг зарцуулж, 79 369.5 мянган төгрөгийн үлдэгдлийг төсөвт буцаан төвлөрүүлж, 64.3 мянган төгрөгийн эцсийн үлдэгдэлтэй.

Тайлант онд 22 объектийн хөрөнгө оруулалтаар 2 059 613.6 мянган төгрөгийн санхүүжилт орж, гүйцэтгэлээр 1 923 858.0 мянган төгрөг зарцуулж харьяа байгууллагуудад хөрөнгийг хүлээн авч, данс бүртгэлд тусгасан. Барьцаа дансанд оны эхэнд 123 831.2 мянган төгрөг, тайлант онд 135 755.6 мянган төгрөг байршуулж, 75 407.1 мянган төгрөгийн барьцаа чөлөөлөгдөж, 184 179.7 мянган төгрөгийн эцсийн үлдэгдэлтэй байна. /үүнээс 2016 оны барьцааны үлдэгдэл 48 424.1 мянга, 2017 оных 135 755.6 мянга/

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу тус байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн shilendans.gov.mn цахим хуудсанд 2017 оны төсвийн хуваарь, түүний гүйцэтгэл, санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш

үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэрэг мэдээллийг байршуулсан эсэхэд 2017 оны 11 дүгээр сард нийцлийн аудит хийгдсэн болно.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 11 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 14 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Санхүүгийн үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайланд орлого, зарлагыг илүү тайлагнасан, үнэ төлбөргүй авсан хөрөнгийг үр дүнгийн тайланд ангилал зөрүүтэй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн, төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан, бараа материалыг дутуу тоолсон, хөрөнгийн ангиллыг зөрүүтэй бүртгэсэн зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн хэмжилт, үнэлгээ, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Эдгээр зөрчлүүд нь төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулах, төсвийн зориулалтыг зөрчих, хөрөнгө дутагдах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй байх зэрэг сөрөг үр дагаварт хүрч болзошгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар

Тус газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний 100.0 мянган төгрөгөөс дээш 232 222 666.0 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, цалин хөлс, НДШ, тээвэр шатахуун, бусад зардал зэрэг дансын ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт мөнгөн хөрөнгийн 80%, нийт орлогын 80%, нийт зардлын 60%, нийт хөрөнгийн 40%-ийг тус тус эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн, Сангийн сайдын баталсан заавар, журмын холбогдох заалтыг зөрчсөнөөс санхүүгийн тайлагналтай холбоотой **12 070 761.0** мянган төгрөгийн **материаллаг** алдаа зөрчил илэрсэн. Үүнд:

- Эмчилгээний төлбөрт үйлчилгээний 9 793.9 мянган төгрөгийн орлогыг дутуу бүртгэсэн, кассын тайлангийн 292.4 мянган төгрөгийн үлдэгдлийг тайлагнаагүй, 155 037.9 мянган төгрөгийн орлогыг тухай бүрд нь тооцооны дансаар /кассаар/ дамжуулан бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 заалт, 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь заалтуудыг мөрдөөгүй; /НШЭНТ 8 027.3 мянга, СХД-ийн ЭМТ 154 423.8 мянга, НЗӨСТ 2 669.5 мянга/;

Шийдвэрлэсэн: Зөрчлийн 9 793.9 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоож, 155 330.3 мянган төгрөгт зөвлөмж өглөө.

- Кассын орлогыг тухай бүрд төрийн санд тушаадаггүй, 74 256.2 мянган төгрөгийг 2-25 хоногоор хугацаа хоцроосон нь Сангийн сайдын 2012 оны “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.6. заалтыг хэрэгжүүлээгүй; */БЗД-ийн ЭМТ 74 256.2 мянга, ХУД-ын НЭ /;*

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өглөө.

- Мөнгөн хөрөнгийн тайланд 10 051.4 мянган төгрөгийн анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж данс бүртгэлд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. заалтыг зөрчсөн; */НШЭНТ 8 000.0 мянга, Хүрээ амаржих 627.4 мянга, БХД-ийн ЭМТ 1 424.0 мянга/;*

Шийдвэрлэсэн: Зөрчлийн 1 424.0 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоож, 8 627.4 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

- ХУД-ын НЭ нь үйл ажиллагааны бус орлогын 7 202.3 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд авч, зарцуулсан;

Шийдвэрлэсэн: Зөвлөмж өглөө.

- Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор 9 989 210.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 100 741.0 мянган төгрөгийн бараа материал, үнэт цаас, нийт 10 089 951.0 мянган төгрөгийн хөрөнгийн тооллогыг заавар журмын дагуу бүрэн хийгдээгүй, актаар баталгаажуулаагүй, бараа материалын тайланг нэр төрлөөр гаргаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1. заалтыг зөрчсөн; */Наркологи эмнэлэг 54 377.2 мянга, БЗД-ийн ЭМТ 43 283.8 мянга, НЭМГ 3 080.0 мянга, СХД-ийн ЭМТ 9 955 272.5 мянга, БХД-ийн ЭМТ 33 937.5 мянга/;*

Шийдвэрлэсэн: Зөрчлийн 77 221.3 мянган төгрөгт албан шаардлага өгч, 57 457.2 мянган төгрөгт зөвлөмж өгч, 9 955 272.5 мянган төгрөгт залруулга хийлгэсэн.

- УИХ-ын 67 дугаар тогтоолын дагуу төрийн албан хаагч бүрт олгосон 300.0 мянган төгрөгийн мөнгөн урамшууллаас 122 432.2 мянган төгрөгийн НДШ-ийг даатгуулагчаас суутгаагүй ЭМЯ-аас санхүүжүүлж төсвөөс төлсөн; */НЭМГ 1 530.0 мянга, Өргөө амаржих 17 370.0 мянга, Хүрээ амаржих 5 490.0 мянга, Амгалан амаржих 7 230.0 мянга, НТТТ 10 300.0 мянга, НЗӨСТ 540.0 мянга, Наркологи эмнэлэг 1 122.0 мянга, БЗД-ийн ЭМТ 12 922.8 мянга, СБД-ийн ЭМТ 13 545.6 мянга, СХД-ийн ЭМТ 12 060.0 мянга, ЧД-ийн ЭМТ 11 160.0 мянга, ХУД-ийн ЭМТ 6 928.8 мянга, ХУД-ийн НЭ 3 780.0 мянга, БНД-ийн ЭМТ 9 420.0 мянга, НД-ийн ЭМТ 10 395.0 мянга, БХД-ийн ЭМТ 1 638.0 мянга/;*

Шийдвэрлэсэн: Зөрчилд албан шаардлага өглөө.

- Тайлант онд 3 000.0 мянган төгрөгийн авлага үүсгэсэн, 71 440.3 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлд тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, анхан шатны баримтаар баталгаажсан 68 188.6 мянган төгрөгийн авлагыг бүртгээгүй, нийт 142 628.9 мянган төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5. “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;” заалт, 5.1.4. “үнэн зөв байх” заалтуудыг зөрчсөн;

/СБД-ийн НЭ 3 000.0 мянга, Амгалан төрөх 9 227.4, НШЭНТ 68 700.9 мянга, БЗД-ийн ЭМТ 496.0 мянга, Энэрэл эмнэлэг 2 673.0 мянга, БЗД-ийн ЭМТ 962.5 мянга, ХУД-ийн НЭ 3 499.4 мянга, НД-ийн ЭМТ 227.5 мянга, БХД-ийн ЭМТ 52 402.6 мянга, Наркологи эмнэлэг 1 439.6 мянга, /

Шийдвэрлэсэн: Зөрчлийн 1 439.6 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоож, 55 142.0 мянган төгрөгт албан шаардлага өгч, 69 890.9 мянган төгрөгийг залруулга хийлгэж, 16 156.4 мянган төгрөгийн зөвлөмж өглөө.

- Ээлжийн амралттай болон өвчтэй чөлөөтэй хугацаанд 16 594.9 мянган төгрөгийн цалин хөлс илүү, 3 657.7 мянган төгрөгийн унааны мөнгө илүү, цагийн ирц бүртгэлгүй хүмүүст 1 600.0 мянган төгрөгийн цалин илүү, 1 614.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа дутуу суутгасан зэрэг нийт 23 466.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэн;

/НЭМГ 147.7 мянга, НТТТ 4 986.1 мянга, НШЭНТ 2 536.4 мянга, БНД-ийн 6 001.3 мянга, НД-ийн ЭМТ 604.7 мянга, БХД-ийн ЭМТ 2 318.7 мянга, ХУД-ийн НЭ 3 657.7 мянга, БХД-ийн ЭМТ 1 614.0 мянга, НШЭНТ 1 600.0 мянга/

Шийдвэрлэсэн: Зөрчлийн 20 782.5 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоож, 2 684.1 мянган төгрөгт зөвлөмж өглөө.

- Цалингийн зардлаас нэг удаагийн буцалтгүй тусламжинд 93 574.5 мянга, мөнгөн шагналд 18 337.4 мянга, нийт 111 911.9 мянган төгрөгийн зардал шилжүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5. заалт, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаал “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 4.1.5 заалт зөрчсөн;

/НШЭНТ 1 394.1 мянга, БГД-ийн ЭМТ 49 934.1 мянга, СБД-ийн НЭ 933.3 мянга, СХД-ийн ЭМТ 21 781.5 мянга, НД-ийн ЭМТ 19 531.5 мянга, ХУД-ийн НЭ 18 337.4 мянга/

Шийдвэрлэсэн: Зөрчилд зөвлөмж өглөө.

- НШЭНТ нь халамжийн үйлчилгээний мөнгөнөөс 8 120.5 мянган төгрөгийг цалингийн нэмэгдэлд олгосон нь Эрүүл мэндийн сайдын 277 дугаар тушаал “Тусламж үйлчилгээг төлбөртэй үзүүлэх журам”-ын 1 дүгээр бүлгийн 3 дугаар заалт зөрчсөн;

Шийдвэрлэсэн: Зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

- Хүнд хортой нөхцөлийн нэмэгдэлд 12 346.4 мянган төгрөг хавтгайруулан олгосон нь өмнөх аудитын зөвлөмжийг биелүүлээгүй, Засгийн газрын 2012 оны “Эрүүл мэндийн ажилтанд нэмэгдэл, мөнгөн урамшил олгох журам”-ын 1.4.заалт, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны “Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт”-ын 15, 28, 30, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 заалтуудыг хэрэгжүүлээгүй;

/Амгалан амаржих 2 017.2 мянга, Энэрэл эмнэлэг 10 329.2 мянга/;

Шийдвэрлэсэн: Зөрчлийн 2 017.2 мянган төгрөгт албан шаардлага өгч, 10 329.2 мянган төгрөгт зөвлөмж өглөө.

- НТТТ нь үр дүнгийн урамшууллыг олгохдоо шалгуур үзүүлэлтээр ажлыг дүгнээгүй, үндсэн цалинг 50-100 хувиар нэмэгдүүлэн тооцож 18 698.0 мянган төгрөг олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2, 31.3,

31.1.3, Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид шагнал, урамшуулал олгох журам"-ын 5 заалт, тус байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 8.4 заалтуудыг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Зөрчилд зөвлөмж өглөө.

- БНД-ийн ЭМТ-д Арабын нэгдсэн Эмирт улсын элчин сайдын санхүүжилтээр бэлтгэгдэх хөрөнгө оруулалтад тендер зарлаагүй, хувийн компанитай шууд гэрээ байгуулж санхүүжилтийг 100 хувь олгож, бэлтгэгдсэн 506 670.9 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй хөрөнгө оруулалтын зардалд тооцсон. Мөн үнийн харьцуулалтгүй, гэрээ байгуулаагүйгээр төсвөөс 83 972.9 мянган төгрөгийн бараа худалдан авсан нь "Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.1.1 заалтыг зөрчсөн;

Шийдвэрлэсэн: Зөрчлийн 590 643.8 мянган төгрөгт албан шаардлага өглөө.

- БЗД-ийн ЭМТ нь өөрийн эзэмшил газарт хувийн барилга бариулсан;

Шийдвэрлэсэн: Зөрчилд зөвлөмж өглөө.

- Бараа материалын тайланд 3 938.2 мянган төгрөгийн анхан шатны баримтгүй, 98 538.2 мянган төгрөгийн бүрдэл дутуу баримтаар эм тариа, шатахуун зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. заалт зөрчөн;

ИНТТТ 110.0 мянга, БНД-ийн ЭМТ 49 697.7 мянга, БХД-ийн ЭМТ 910.0 мянга, НЗӨСТ 13 226.0 мянга, БЗД-ийн ЭМТ 15 000.0 мянга, Наркологи эмнэлэг 23 532.7 мянга /;

Шийдвэрлэсэн: Зөрчлийн 3 938.2 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоож, 75 005.5 мянган төгрөгт албан шаардлага өгч, 23 532.7 мянган төгрөгт зөвлөмж өглөө.

- Шатахууны тайланд 4 429.1 мянган төгрөгийн шатахууны нэгжийн үнийг буруу бүртгэсэн, 13 337.4 мянган төгрөгийн шатахуун зарцуулалтыг үнэн зөвөөр бүрэн хөтлөөгүй, нормоос илүү дутуу тооцсон, анхан шатны баримтын бүрдэл дутуу, нийт 17 766.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн;

/БЗД-ийн ЭМТ 4 429.1 мянга, НЗӨСТ 13 137.4 мянга, НТТТ 200.0 мянга/;

Шийдвэрлэсэн: Зөрчлийн 17 566.5 мянган төгрөгт албан шаардлага өгч, 200.0 мянган төгрөгт зөвлөмж өглөө.

- Бараа материалын дансанд бүртгэлгүйгээр 13 520.0 мянган төгрөгийн материалыг засварын зардалд тооцсон, ашиглагдаж байгаа 7 284.9 мянган төгрөгийн хангамжийн материалыг данс бүртгэлээс хассан, төсөвлөгдөөгүй ажилд 31 250.8 мянган төгрөгийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан зэрэг нийт 52 055.7 мянган төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 заалт, 6 дугаар зүйлийн 6.4.1 заалтуудыг зөрчиж, Сангийн сайдын 2006 оны "Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар"-ын 4.21 дэх заалтыг хэрэгжүүлээгүй;

/Наркологи эмнэлэг 6 560.0 мянга, БЗД-ийн ЭМТ 6 960.0 мянга, БГД-ийн ЭМТ 7 284.9 мянга, БНД-ийн ЭМТ 25 147.3 мянга, НД-ийн ЭМТ 6 103.5 мянга/;

Шийдвэрлэсэн: Зөрчлийн 942.0 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоож, 12 484.0 мянган төгрөгт албан шаардлага өгч, 38 629.7 мянган төгрөгт зөвлөмж өглөө.

- Үндсэн хөрөнгийг 93 442.2 мянган төгрөгөөр орлогод дутуу, 137 580.1 мянган төгрөгөөр ангилал буруу бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны "Төсөв байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар"-ын 4.30. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4. заалт, УСНББОУС-17 холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй;
/БНД-ийн ЭМТ 93 442.2 мянга, СБД-ийн ЭМН 5 327.7 мянга, СБД-ийн НЭ 44 328.4 мянга, СХД-ийн НЭ 4 455.0 мянга, НД-ийн ЭМТ 83 469.0 мянга/

Шийдвэрлэсэн: Зөрчлийн 49 656.1 мянган төгрөгт зөвлөмж өгч, 181 366.2 мянган төгрөгт залруулга хийлгэсэн.

- Тайланд тусгаагүй өмнөх оны 26 218.0 мянган төгрөгийн өр төлбөрийг тайланд оны төсвөөс зарцуулсан, 7 206.5 мянган төгрөгийн өглөгийг дутуу бүртгэсэн, 252 584.1 мянган төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зэрэг нийт 286 008.6 мянган төгрөгийн зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5. заалт, 5 дугаар зүйлийн 5.1.4. заалтуудыг хэрэгжүүлээгүй.
/БХД-ийн ЭМТ 7 086.5 мянга, СБД-ийн НЭ 26 218.0 мянга, НЭМГ 636.7 мянга, Наркологийн эмнэлэг 71 782.7 мянга, БНД-ийн ЭМТ 180 284.7 мянга/

Шийдвэрлэсэн: Зөрчлийн 187 371.2 мянган төгрөгт албан шаардлага өгч, 26 854.7 мянган төгрөгт зөвлөмж өгч, 71 782.7 мянган төгрөгт залруулга хийлгэсэн.

- НТТТ нь албаны бус хэрэгцээнд зарцуулсан 616.1 мянган төгрөгийн шатахуун, илүү цагийн хөлс төсвөөс олгосон нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 заалт зөрчсөн;

Шийдвэрлэсэн: Зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

- ХХОАТ-ыг 3 982.0 мянган төгрөгөөр илүү суутгасан;
/Амгалан амаржих 723.0 мянга, НТТТ 1 030.0 мянга, БГД-ийн ЭМТ 1 113.0 мянга, ЧД-ийн ЭМТ 1 116.0 мянга/

Шийдвэрлэсэн: Зөрчилд зөвлөмж өглөө.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт "үнэн зөв байх", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар журам"-ын холбогдох заалтыг зөрчсөнөөс **2 854 779.2** мянган төгрөгийн **материаллаг бус** алдаа зөрчил илэрлээ. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайланд Амгалан амаржих газар санхүүгийн байдлын тайлан, тодруулгын тайланд 3 960.0 мянга, Энэрэл эмнэлэг 68.4 мянга, нийт 4 028.4 мянган төгрөгөөр зөрүүтэй нэгтгүүлсэн нь Сангийн сайдын 2006 оны "Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар"-ын 3.2 заалтыг хэрэгжүүлээгүй.

Шийдвэрлэсэн: Зөрчилд залруулга хийлгэсэн

- Санхүүгийн байдлын тайлангийн “хөрөнгийн дахин үнэлгээний нөөц”-ийн 189 672.7 мянган төгрөг нь үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд нэр төрлөөр тусгагдаагүй, тодорхой бус, хяналтгүй байгаа нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар”-ын 4.44 заалтыг хэрэгжүүлээгүй;
ИНЗӨСТ 71 394.8 мянга, Наркологийн эмнэлэг 118 277.9 мянга, БНД-ийн ЭМТ, БХД-ийн ЭМТ;

Шийдвэрлэсэн: Зөрчилд залруулга хийлгэсэн.

- Санхүүгийн үр дүнгийн тайланд актлагдсан бараа материалын зардлыг 21 934.0 мянган төгрөгөөр дутуу, нэмэлт санхүүжилтийн орлого зарлагыг 6 605.0 мянган төгрөгөөр илүү, цалин НДШ-ийн зардлыг 2 581.1 мянган төгрөгөөр илүү, нийт 31 120.1 мянган төгрөгөөр алдаатай тайлагнасан нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар”-ын 2.1.4 заалтыг мөрдөөгүй;
/БЗД-ийн ЭМТ 21 934.0 мянга, СБД-ийн ЭМТ 6 605.0 мянга, ХУД-ын ЭМТ 2 581.1 мянга/

Шийдвэрлэсэн: Зөрчлийн 2 581.1 мянган төгрөгт зөвлөмж өгч,
28 539.0 мянган төгрөгийн залруулга хийлгэсэн.

- Мөнгөн гүйлгээний тайланд 1 485.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгийг дутуу, 264 320.7 мянган төгрөгийн жирэмсэн амаржсаны болон ХЧТАТ-ийн орлого, зарлагыг илүү, нийт 265 805.7 мянган төгрөгөөр алдаатай тайлагнасан;
/БЗД-ийн ЭМТ 1 485.0 мянга, Өргөө амаржих 161 099.9 мянга, БЗД-ийн ЭМТ 41 270.8 мянга, СБД-ийн НЭ 61 950.0 мянга/

Шийдвэрлэсэн: Зөрчилд залруулга хийлгэсэн.

- Наркологийн эмнэлэг төсвийн гүйцэтгэлийн тайланд эх үүсвэрийг 13 068.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан;

Шийдвэрлэсэн: Зөрчилд залруулга хийлгэсэн.

- Тодруулгын тайланд үнэ төлбөргүй ирсэн 44 443.9 мянган төгрөгийн хөрөнгийг илүү тайлагнасан;
/БНД-ийн ЭМТ 33 192.9 мянга, БХД-н ЭМТ 11 251.0 мянга/ ;

Шийдвэрлэсэн: 33 192.9 мянган төгрөгийн зөрчилд залруулга хийлгэж, 11 251.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

- Урьдчилгаа цалин дансны 2 188 764.4 мянга, ХЧТАТ-ийн тооцоо дансны 43 894.6 мянга, нийт 2 232 659.7 мянган төгрөгийн журналын бичилтийг нягтлан бодох бүртгэлд алдаатай буруу бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар журам”-ыг мөрдөөгүй;
/БЗД-ийн ЭМТ 471 748.4 мянга, НД-ийн ЭМТ 5 431.3 мянга, СБД-ийн НЭ 561 508.7 мянга, СХД-ийн ЭМТ 1 193 970.6 мянга/

Шийдвэрлэсэн: Зөрчилд залруулга хийлгэсэн.

- ХУД-ын НЭ нь өмнөх оны жижиг мөнгөн сангийн үлдэгдэл 750.0 мянган төгрөгийг кассын тайланд тусгаагүй, тайлант онд зарцуулсан, мөнгөн хөрөнгөөс 47 917.4 мянган төгрөгийн гүйлгээг тооцооны дансаар дамжуулан бүртгээгүй;

Шийдвэрлэсэн: Дансны бичилтэнд залруулга хийлгэсэн.

- Хөдөлмөрийн хууль зөрчин ажилтанг амралтгүйгээр үргэлжлүүлэн илүү цагаар ажиллуулж илүү цагийн хөлсийг хавтгайруулан олгосон Хөдөлмөрийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.3 заалтыг хэрэгжүүлээгүй;
/БГД-ийн ЭМТ, ХУД-ийн НЭ, бусад эмнэлэгүүдэд нийтлээ/

Шийдвэрлэсэн: Зөрчилд зөвлөмж өглөө.

- УИХ-ын 29 дүгээр тогтоол зөрчин алба хаагчдын албан тушаалын цалингийн зэрэглэл, шатлал ахиулан 8 906.3 мянган төгрөгийн цалин нэмэгдүүлэн олгосон;
/Өргөө амаржих 309.3 мянга, Хүрээ амаржих 1 630.8 мянга, ХУД-ийн НЭ 6 966.2 мянга/

Шийдвэрлэсэн: Зөрчилд зөвлөмж өглөө.

- Үндсэн хөрөнгийг ангилал шилжүүлэн бараа материал дансанд 16 630.7 мянган төгрөгөөр бүртгэсэн нь цэвэр дүнгээр тооцоогүй, хасагдсан 527.0 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлэн орлогод авахдаа хуримтлагдсан элэгдлийн дүнгээр бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны "Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар"-ын 4.16. заалтыг мөрдөөгүй; */НЭМГ 16 630.7 мянга, Өргөө амаржих 527.0 мянга/*

Шийдвэрлэсэн: Зөрчилд залруулга хийлгэсэн.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Аудитаар илэрсэн нийт 1 815 187.1 мянган төгрөгийн зөрчлийг залруулга хийлгэх боломжгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн хөрөнгөд биет тест хэрэгжүүлээгүй, эм бэлдмэлийн зардал, төлбөрт үйлчилгэний болон эрүүл мэндийн даатгалын сангаас олгож байгаа орлогууд, өвчтөний хоолны зардал түүний норм зэрэг нь эрсдэлтэй байж болох асуудлыг 2018 оны завсрын аудитаар шалгахар тогтов.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал

НЭМГ нь нийслэлийн хэмжээний 2 дугаар шатлалын эмнэлгүүдийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэн гаргаж байгаа боловч тэдгээр байгууллагуудын төсвийг захирах ямар нэг эрх үүрэггүй юм.

УАУЭСКТ нь 2017 оны орлого түүний зарцуулалтыг аудитад шалгуулахаас татгалзсан, санхүүгийн тайлан, холбогдох анхан шатны баримтуудыг НТАГ-д бүрэн ирүүлээгүй.

Цалин хөлсийг урамшуулал, илүү цаг, нэмэгдэл үр дүн нэрээр харилцан адилгүй олгож байгаа нь Төрийн албаны тухай хуулийн 28.4 “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээ, жишгийг тогтооход дараахь шаардлагыг харгалзан үзнэ”, 28.4.1 “төрийн адил албан тушаалд адил хэмжээний цалин хөлс тогтоох” заалтыг баримтлахгүй байна.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт **14 925 540.2** мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс **13 110 353.1** мянган төгрөгийн алдааг залруулга хийлгэж, **47 056.8** мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, **1 214 139.9** мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, **553 990.4** мянган төгрөгийн зөрчилд давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар 13 зөвлөмж өгснөөс 6 зөвлөмжийг хэрэгжүүлж, 7 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, он удаан жил болсон авлагыг барагдуулах арга хэмжээ авах;
- Анхан шатны баримтын бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах;
- Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, заавар журмын дагуу чанартай хийх;
- Цалингийн нэмэгдлүүдийг илүү олгохгүй байх;
- Төсвийг зориулалт бусаар зарцуулахгүй байх;
- Хөрөнгийн ангилал буруу бүртгэхгүй байх;
- Өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, тайланд тусгах;

Хязгаарлалтай санал дүгнэлт

Дээрх алдаа зөрчлийг эс тооцвол нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан 11 хуудас, хавсралтууд 13 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Хянасан:

Дэд дарга, тэргүүлэх аудитор

Санхүүгийн аудитын II хэлтсийн дарга
бөгөөд аудитын менежер

Бэлтгэсэн:

Аудитор



Б.Баттуяа

Ц.Бат-Өлзий

Б.Тэгшлхам

2018 оны 03 дугаар сар 23

Аудит хийсэн:

Ахлах аудитор

Ахлах аудитор

Ахлах аудитор

Ахлах аудитор

Аудитор

Аудитор

Аудитор

Аудитор

Аудитор

Аудитор

Аудитор

Аудитор

Аудитор

Аудитор

Аудитор

Аудитор

Аудитор

Аудитор

Аудитор

А.Цогбаяр

Д.Энхдалай

Д.Жаргалсайхан

Я.Алтанцэцэг

Д.Нарантуяа

Ж.Мөнхтуяа

З.Ганцэцэг

В.Эрдэнэцогт

Х.Оюунчимэг

С.Гантөгс

Ж.Энхтуяа

И.Эрдэнэцэцэг

М.Лхагвасүрэн

Н.Бадамхатан

Б.Лхагвацэнд

Ц.Батсүх

Г.Долгорсүрэн

Ё.Лхагвадулам

Н.Баттогоо

2018.03.22

Нийслэлийн эрүүл мэндийн харьяа байгууллагуудын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

№	Байгууллагын нэр	Зөрчлийн дүн				Зөрчлийн тайлан, үр дүнгийн тайлан, Мөнгөн багатаажуулалт хийгдээгүй	Санхүүгийн нэгтгэсэн тайланд	/мянган.төгрөг/							
		Зөрчлийн дүн	Зааруулсан	Зааруулаагүй	Акт				Үүнээс	Зөвлөмж					
1	Нийслэлийн Эрүүл мэндийн газар	5,394.4		5,394.4											
2	Өргөө амаржих /1-р төрөх/	192,936.9	178,257.6	14,679.3			3,884.4	Он удаан жил болсон тооцоо нийслэлийн авлагыг барагдуулаагүй, баталгаажуулаагүй							
3	Хүрээ амаржих /2-р төрөх/	7,748.2		7,748.2			309.3								
4	Амгалан амаржих /3-р төрөх/	23,157.6	3,960.0	19,197.6			2,258.2								
5	Түргэн тусламжийн төв	35,740.2		35,740.2	5,712.2		11,490.6	Таилан болон үндсэн хөрөнөг, бараа материалын тодруулга тайланд хөрөнгийн ангилал заруусан							
6	Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төв	100,967.7	71,394.8	29,572.9			7,707.0								
7	Наркологийн эмнэлэг	290,360.1	203,128.6	87,231.5	1,439.6		26,903.4	3,960.0							
8	Шүд эрүү нүүрний төв	98,379.2	68,700.9	29,678.3	17,455.4		12,222.9								
9	Энэрэл эмнэлэг	13,070.6	68.4	13,002.2			13,002.2	68.4							
10	Уламжлалт Анагаах ухааны элэг судлалын клиникийн төв	5,607,608.9		5,607,608.9				5,607,608.9							
11	Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв	58,332.0		58,332.0			58,332.0								
12	Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв	694,748.6	537,400.7	157,347.9			6,960.0								
13	Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төв	25,478.3	6,605.0	18,873.3			5,327.7								
14	Сүхбаатар дүүргийн Нэгдсэн эмнэлэг	697,938.4	623,458.7	74,479.7			74,479.7								
15	Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн т	11,337,512.0	11,149,243.1	188,268.9	2,059.0		174,149.9								
16	Сонгинохайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлэг	4,455.0													
17	Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төв	12,276.0		12,276.0			1,116.0								
18	Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв	9,509.9		9,509.9			2,581.1								
19	Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлэг	91,360.4	47,917.4	43,443.0	3,657.7		3,780.0								
20	Багануур дүүргийн Эрүүл мэндийн төв	987,829.9	126,635.1	861,194.8	9,861.5		839,612.0								
21	Налайх дүүргийн Эрүүл мэндийн төв	125,762.5	89,127.8	36,634.7	604.7		10,395.0								
22	Багахангай дүүргийн Эрүүл мэндийн төв	112,582.3		112,582.3	6,266.7		95,064.6								
	Нэгтгэлийн дүн	20,533,149.1	13,110,353.1	7,422,796.0	47,056.8		1,214,139.9	553,990.4							
	Залуулагүй	13,110,353.1													
	Залуулагүй	7,422,796.0	13,110,353.1	7,422,796.0	47,056.8		1,214,139.9	553,990.4							
	Акт	47,056.8													
	Албан шаардлага	1,214,139.9													
	Зөвлөмж	553,990.4													
	Татгалзсан	5,607,608.9													
Үүнээс							5,607,608.9	4,028.4	5,611,637.3	70,944.3			68,700.9	2,243.4	2,243.4

Зөрчлийн хүснэгт нэгтгэн гаргасан:

НТАГ-ын САХ-н 2-р аудитор

Аудит хийсэн: Ахлах аудитор

Аудитор

Аудитор

Б.Тэлшхам

А.Цолбаяр

А.Энхдалай

Д.Жаргалсайхан

Я.Алтанцэцэг

Д.Нарантуяа

Аудитор

З.Ганцэцэг

Ж.Мянхтуяа

В.Эрдэнэцогт

Х.Оюунчимэг

С.Гантөгс

Ж.Энхтуяа

И.Эрдэнэцэцэг

Аудитор

М.Луувгасүрэн

Н.Бадамхатан

Б.Лхагвацэнд

Ц.Батсүх

Г.Долгорсүрэн

Н.Баттоого

Е.Лхагвадулам

Үйлчлүүлэгч байгууллагын хариу:



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо,
Бага тойруу-3, Ц.Жигжиджавын гудамж-9,
Нийслэлийн засаг захиргааны II байр, Хангарди ордон
Утас/Факс: (976-11) 32-50-76
E-mail: ubhd@emg.ub.gov.mn, http://www.ubhealth.mn

2018.03.23 № 1/292
танай 2018.03.22 -ны № 865 -Т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Менежментийн захидал хүргүүлэх тухай

Танай 2018 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 865 дугаар албан тоотой ирүүлсэн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайланд баталгаажуулах аудит хийсэн "Менежментийн захидал"тай танилцлаа.

УАУЭСКТ нь бэлнээр орсон өөрийн орлогыг төрийн сангийн дансанд төвлөрүүлдэггүй, орлого түүний зарцуулалтыг аудитад шалгуулахаас татгалзаж, санхүүгийн тайланд холбогдох анхан шатны баримтуудыг ирүүлээгүй зөрчлийг дахин гаргахгүй ажиллахыг шаардаж холбогдох арга хэмжээг авч ажиллана.

БХД-ийн ЭМТ нь санхүүгийн тайлангаа хугацаа хоцроосоныг сануулж дахин хоцроохгүй байх арга хэмжээ авна.

ХУД-ын НЭ нь үйл ажиллагааны бус орлогыг зарцуулсан зөрчил гаргасныг шаардлага тавьж холбогдох арга хэмжээг авч ажиллана.

ШЭНТ, СХД-ийн ЭМТ төлбөрт үйлчилгээний орлогыг дутуу бүртгэж тайланд тусгаагүй, кассын орлогыг тухай бүрд төрийн санд тушаадаггүй зөрчлийг холбогдох арга хэмжээ авч зөрчлийг дахин гаргахгүй байх арга хэмжээг авч ажиллана.

Мөн тооллогыг хангалтгүй хийдэг, санхүүгийн байдлын тайлан, тодруулга тайлан зөрүүтэй тайлагнах, анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар орлого зарлага гаргадаг, өглөг авлагын тооцоо нийлсэн акт үйлдээгүй зэрэг дээрх зөрчил дутагдлыг гаргасан холбогдох байгууллагын дарга, нягтлан бодогч нарт Аудитын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу зохих арга хэмжээг авч ажиллах болно.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

1150500158

Менежментийн захидал

НТАГ газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийн менежментийн захидлыг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Иймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

НТАГ-ын энэхүү зөвлөмж танай бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлэх нь танай байгууллагын үүрэг юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Нийслэлийн Эрүүл мэндийн газар, харьяа байгууллагуудын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Санхүүгийн нэгтгэсэн тайлан**НТАГ-ын ажиглалт:**

- УАУЭСКТ нь 2017 оны орлого түүний зарцуулалтыг аудитад шалгуулахаас татгалзаж, санхүүгийн тайлан холбогдох анхан шатны баримтуудыг НТАГ-д бүрэн ирүүлээгүй нь Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх заалт "Төрийн аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, аудит хийлгэхээс зайлсхийсэн, шаардлагатай мэдээлэл, баримт материалыг гаргаж өгөхөөс үндэслэлгүй татгалзсан, аудитад нөлөөлөхийг оролдсон, санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай, сөрөг санал, дүгнэлт авсан, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитаар материаллаг шинжтэй зөрчил гаргасан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй.

- БХД-ийн ЭМТ нь 2017 оны санхүүгийн тайланг 6 хоногоор хугацаа хоцроосон, тайлангийн тодруулга илтгэх хуудас хавсаргаагүй.

- Санхүүгийн нэгтгэсэн тайланд Амгалан амаржих газар санхүүгийн байдлын тайлан, тодруулгын тайланд 3 960.0 мянга, Энэрэл эмнэлэг 68.4 мянга, нийт 4 028.4 мянган төгрөгөөр зөрүүтэй нэгтгүүлсэн нь Сангийн сайдын 2006 оны "Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар"-ын 3.2 заалтыг хэрэгжүүлээгүй.

Эрсдэлүүд:

Санхүүгийн тайланг нэгтгэхдээ бүрэн, үнэн, зөв тайлагнаагүй байх;

Тэргүүлэх ач холбогдол 1:**НТАГ -ын зөвлөмж:**

Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн заалтыг хэрэгжүүлж ажиллах;

Төсвийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 8.9.1."төсвийн шууд захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх; хэрэгжүүлж ажиллах;

Нэгтгэсэн тайланд байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангуудыг үнэн, зөв нэгтгэж байх;

Төсвийн захирагчийн хариу

Хариу ирүүлсэн.

Асуудал 2: Санхүүгийн тайлагнал**НТАГ-ын ажиглалт:**

- Санхүүгийн байдлын тайлангийн "хөрөнгийн дахин үнэлгээний нөөц"-ийн 189 672.7 мянган төгрөгийн дүн нь үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд нэр төрлөөр тусгагдаагүй тодорхойгүй; ИНЗӨСТ 71 394.8 мянга, Наркологийн эмнэлэг 118 277.9 мянга, БНД-ийн ЭМТ, БХД-ийн ЭМТ;

Тэргүүлэх ач холбогдол 1:**НТАГ -ын зөвлөмж:**

Санхүүгийн тайланг холбогдох заавар, журмын дагуу үнэн, зөв тайлагнаж байх;

- Санхүүгийн үр дүнгийн тайланд актлагдсан бараа материалын зардлыг 21 934.0 мянган төгрөгөөр дутуу, нэмэлт санхүүжилтийн орлого зарлагыг 6 605.0 мянган төгрөгөөр илүү, цалин НДШ-ийн зардлыг 2 581.1 мянган төгрөгөөр илүү, 31 120.1 мянган төгрөгөөр алдаатай тайлагнасан нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар”-ын 2.1.4 “Санхүүгийн бүртгэл, тайлан нь бодит баримт, тоо мэдээнд үндэслэсэн байх” заалт хэрэгжүүлээгүй;

/БЗД-ийн ЭМТ 21 934.0 мянга, СБД-ийн ЭМТ 6 605.0 мянга, ХУД-ын ЭМТ 2 581.1 мянга/

- Мөнгөн гүйлгээний тайланд 1 485.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгийг дутуу, 264 320.7 мянган төгрөгийн жирэмсэн амаржсаны болон ХЧТАТ-ийн орлого, зарлагыг илүү, нийт 265 805.7 мянган төгрөгөөр алдаатай тайлагнасан;/БЗД-ийн ЭМТ 1 485.0 мянга, Өргөө амаржих 161 099.9 мянга, БЗД-ийн ЭМТ 41 270.8 мянга, СБД-ийн НЭ 61 950.0 мянга/

- Наркологийн эмнэлэг төсвийн гүйцэтгэлийн тайланд эх үүсвэрийг 13 068.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан;

- Тодруулгын тайланд үнэ төлбөргүй ирсэн 44 443.9 мянган төгрөгийн хөрөнгийг илүү тайлагнасан;

/БНД-ийн ЭМТ 33 192.9 мянга, БХД-н ЭМТ 11 251.0 мянга/ ;

Эрсдэлүүд:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;

Холбогдох хууль, тогтоомж, заавар журам хэрэгжихгүй байх

Асуудал 3: Орлогын бүртгэл

НТАГ-ын ажиглалт:

- Бэлнээр орсон ариутгалт халдваржуулалтын, төлбөрт үйлчилгээний 155 034.3 мянган төгрөгийн орлогыг тухай бүрд нь тооцооны дансаар /кассаар/ дамжуулан бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1. “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө.” заалтыг зөрчсөн;

/НЗӨСТ 2 669.5 мянга, СХД-ийн ЭМТ 152 364.8 мянга/;

- ХУД-ын НЭ нь үйл ажиллагааны бус орлогын 7 202.3 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд авч, зарцуулсан;

Санхүүгийн үр дүнгийн тайланд орлого, зарлагын ангиллыг холбогдох заавар, журмын дагуу үнэн зөв тайлагнаж байх;

Мөнгөн гүйлгээний тайланд орлого, зарлагын ангиллыг холбогдох заавар, журмын дагуу үнэн зөв тайлагнаж байх;

Төсвийн гүйцэтгэлийн тайланг холбогдох заавар, журмын дагуу үнэн зөв тайлагнаж байх;

Санхүүгийн тайлангийн тодруулгыг холбогдох заавар, журмын дагуу үнэн зөв тайлагнаж байх;

Төсвийн захирагчийн хариу

НЭМГ-ын даргын 2018 оны 3 сарын 23-ны өдрийн 1/292 дугаар албан бичгээр хариу ирүүлсэн.

Тэргүүлэх ач холбогдол 1:

НТАГ -ын зөвлөмж:

Үйл ажиллагааны орлогыг холбогдох заавар журмын дагуу үнэн зөв тооцож, санхүүгийн тайланд үнэн, зөв тайлагнах;

Эрсдэлүүд:

Санхүүгийн тайланд орлого дутуу тусгах илэрхийлэгдэх;

Холбогдох хууль, тогтоомж, заавар журам хэрэгжихгүй байх

Төсвийн захирагчийн хариу

НЭМГ-ын даргын 2018 оны 3 сарын 23-ны өдрийн 1/292 дугаар албан бичгээр хариу ирүүлсэн.

Асуудал 4: Мөнгөн хөрөнгө**НТАГ-ын ажиглалт:**

- Эмчилгээ, төлбөрт үйлчилгээний 10 086.3 мянган төгрөгийн орлогыг дутуу бүртгэж тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 дэх "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3 дахь "бүх өр төлбөрийг заавал бүртгэнэ" заалтыг мөрдөөгүй;

ИШЭНТ 8 027.3 мянга, СХД-ийн ЭМТ 2 059.0 мянга/;

- Кассын орлогыг тухай бүрд төрийн санд тушаадаггүй, 74 256.2 мянган төгрөгийг 2-25 хоногоор хугацаа хоцроосон нь Сангийн сайдын 2012 оны "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2.6. "Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн кастаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана" заалтыг хэрэгжүүлээгүй;

БЗД-ийн ЭМТ 74 256.2 мянга, ХУД-ын НЭ-/;

- ХУД-ын НЭ нь өмнөх оны жижиг мөнгөн сангийн үлдэгдэл 750.0 мянган төгрөгийг кассын тайланд тусгаагүй, тайлант онд зарцуулсан. мөнгөн хөрөнгөөс 47 917.4 мянган төгрөгийн гүйлгээг тооцооны дансаар дамжуулан бүртгээгүй;

- Мөнгөн хөрөнгийн анхан шатны бүрдэл дутуу 10 051.4 мянган төгрөгийн баримтаар гүйлгээ хийж данс бүртгэлд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." заалтыг зөрчсөн;

ИШЭНТ 8 000.0 мянга, Хүрээ амаржих 627.4 мянга, БХД-ийн ЭМТ 1 424.0 мянга/;

Эрсдэлүүд:

Санхүүгийн тайланд мөнгөн хөрөнгө зөрүүтэй илэрхийлэгдэх;

Холбогдох хууль, тогтоомж, заавар журам хэрэгжихгүй байх

Тэргүүлэх ач холбогдол 1:**НТАГ -ын зөвлөмж:**

Бэлэн мөнгөний орлогод бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, тайланд бүрэн үнэн тусгаж байх;

Үйл ажиллагааны орлогыг төрийн сангийн дансанд хугацаанд нь төвлөрүүлж, мөнгөн кассын ажиллагааны журам мөрдөж ажиллах;

Жижиг мөнгөн сангийн журам мөрдөж ажиллах, дансны бичилт зөв хийх;

Анхан шатны баримтын бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах;

Төсвийн захирагчийн хариу

Асуудал 5: Авлага**НТАГ-ын ажиглалт:**

- Тайлант онд 3 000.0 мянган төгрөгийн авлага үүсгэсэн, 71 440.3 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлд тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, 68 188.6 мянган төгрөгийн авлагыг бүртгээгүй, нийт 142 628.9 мянган төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6.4.8. "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5. "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" заалт, 5.1.4. "үнэн зөв байх" заалтуудыг зөрчсөн;

/СБД-ийн НЭ 3 000.0 мянга, Амгалан төрөх 9 227.4 мянга, НШЭНТ 68 700.9 мянга, БЗД-ийн ЭМТ 496.0 мянга, Энэрэл эмнэлэг 2 673.0 мянга, БЗД-ийн ЭМТ 962.5 мянга, ХУД-ийн НЭ 2 347.7 мянга, НД-ийн ЭМТ 227.5 мянга, БХД-ийн ЭМТ 52 402.6 мянга/

Эрсдэлүүд:

Авлага барагдуулах арга хэмжээ аваагүй байх;

Авлагын үлдэгдэлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байх;

Асуудал 6: Бараа материал**НТАГ-ын ажиглалт:**

- Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор нийт 100 741.0 мянган төгрөгийн бараа материал, үнэт цаасны тооцоо бодоогүй актаар баталгаажуулаагүй, бараа материалын тайланг нэр төрлөөр гаргаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1. "Тооллогын комисс дараахь үүрэгтэй: 1/ эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах;" заалтыг зөрчсөн;

/Наркологи эмнэлэг 54 377.2 мянга, БЗД-ийн ЭМТ 42 283.8 мянга, НЭМГ 3 080.0 мянга/

- Үндсэн хөрөнгийг ангилал шилжүүлэн бараа материал дансанд 16 630.7 мянган төгрөгөөр бүртгэсэн нь цэвэр дүнгээр тооцоогүй, хасагдсан 527.0 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлэн орлогод авахдаа хуримтлагдсан элэгдлийн дүнгээр бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны "Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар"-ын 4.16. "Бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг мөрдөнө." заалтыг хэрэгжүүлээгүй;

/НЭМГ 16 630.7 мянга, Өргөө амаржих 527.0 мянга/

